

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын 2023, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн
шалгалтын танилцуулга

1 хувийг СХДАГ-т

1 хувийг ГХБХБГ-т

У. Дорногой
Д. Золзодор
Зорилго, зорилго, зорилго
хүнийг хүндэтгэн
хүндэтгэн
хүндэтгэн

2025.01.17

2025 он



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 29/05

Арнийхаар сум

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийсэн тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

"Төсвийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтад "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69.3-д "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4.9-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү дүрмийн 5 дахь хэсэгт заасан хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд шаардлагтай тохиолдолд бүх шатны төсөв захиран зарцуулагчдын үйл ажиллагаанд энэхүү дүрмийн хүрээнд хяналт тавьж болно" гэсэн заалтууд болон "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт" зэргийг тус тус үндэслэн хяналт шалгалтыг явууллаа.

Хоёр. Шалгалтын зорилго

Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр баталсан СХШХ/06 дугаар удирдамж, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр баталсан 29/03 дугаар удирдамжийн дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Нийгмийн даатгалын тухай", "Хөдөлмөрийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай", "Газрын тухай", "Газрын төлбөрийн тухай" хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийг шинэчлэн тогтоох тухай" 182 дугаар тогтоол, Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 08/04 дүгээр тогтоол, бусад удирдах дээд байгууллагуудын

67 9 301

шийдвэр, заавар, журмуудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргахад чиглэгдэв.

2.1. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах" тухай Б/10 дугаар тушаалаар байгууллагын дарга 1, газрын удирдлагын хэлтсийн дарга 1, барилга хот байгуулалтын хэлтсийн дарга 1, захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч 1, барилгын техникийн улсын байцаагч 1, ерөнхий нягтлан бодогч 1, мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн 1, архивын ажилтан (нярав) 1, жолооч 1, газрын зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн 1, газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн 1, геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, газрын даамал 21 нийт 42 хүний орон тоотойгоор батлагдаж, батлагдсан орон тооны дагуу үйл ажиллагаагаа явуулжээ. Улсын бүртгэлийн дугаар 1069001173, байгууллагын регистрийн дугаар 9044167.

Шалгагдсан хугацааны баримт дээр нэгдүгээр гарын үсгийг байгууллагын дарга Т.Ариунболд, хоёрдугаар гарын үсгийг 2023 оны 01 дүгээр сараас 2023 оны 07 дугаар сар хүртэл хугацаанд нягтлан бодогч С.Цэрэнханд, 2023 оны 07 дугаар сараас нягтлан бодогч Д.Золзаяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулж иржээ.

Гурав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хамрах хүрээ, хугацаа:

Шалгалт явуулахдаа санхүүгийн баримтыг банкны хуулга болон анхан шатны баримтууд, тайлан тооцоо бодсон актуудтай тулган баталгаажуулах, асууж тодруулах, газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж бүрээр ирүүлсэн судалгааг нягтлан шалгаж, газрын кадастрын мэдээллийн систем, газрын төлбөр татварын нэгдсэн системд газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг хэрхэн бүртгэн хөтөлж байгаад нэмж тодруулга авах байдлаар шалгалтыг аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Дуламжаргал, аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ч.Буянбат, Д.Чулуунбадрах, Э.Энхтуяа нар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Хяналт шалгалтад хамрагдах асуудлууд

4.1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын, сумдын Засаг даргын газар олгохтой холбогдон гарсан захирамж шийдвэрүүдийн хэрэгжилт;

"Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаж, мөрдөж ажиллана" гэсэн заалтын дагуу Газар, зохион байгуулалт геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Монгол улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Захиалагчийн хяналтын зардлын нэр төрөл батлах тухай 83 дугаар тушаалаар барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах зардлын ангилал, Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлогын зарцуулалтын талаар авах арга хэмжээг баталж түүний дагуу зарцуулалтыг хийсэн байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг зарцуулахдаа *Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай"* журам, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан *"Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх тухай"* журам, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан *"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"*-ыг баримтлан зарцуулалтыг хийжээ.

Сумдын Засаг даргын газар эзэмшүүлэх, ашиглахтай холбоотой 2023 онд 335, 2024 онд 431 дүгээр захирамжууд гарсан бөгөөд захирамжаар олгогдсон 2718 нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн оруулсан байна.

4.2. Төрийн өмчийн газрыг эзэмшүүлж, ашиглуулахаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон газрын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн системд бүртгэсэн байдал, тайлан мэдээ, түүнд үндэслэн хийгдсэн газрын төлбөр ногдуулалт;

Газрын кадастрын мэдээллийн системийн хөтлөлт, татвар ногдуулалт:

2018 оноос Газрын кадастрын мэдээллийн систем хэрэгжиж эхэлсэн бөгөөд үүнд иргэн, аж ахуйн нэгжийн өргөдлийг бүртгэн, захирамж шийдвэрийг холбох, гэрээ болон гэрчилгээ олгох, өмчийн бүртгэлийн үйл ажиллагааг явуулж иржээ. 2025 оны 04 дүгээр сарын 04-ний байдлаар аймгийн хэмжээнд өмчлөлийн 21649, эзэмшлийн 24622, ашиглалтын 120, нийт 46391 нэгж талбар байгаагаас 11785 эзэмшлийн, 47 ашиглалтын нэгж талбар хүчингүй болж, газрын кадастрын мэдээллийн системд эзэмшлийн 10359, ашиглалтын 73 нэгж талбар бүртгэгдэж, 2022 оноос өмнө шийдвэр нь гарсан эзэмшлийн 144 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 9,8га, 2279 иргэний өвөлжөө, хаваржааны зориулалттай 159,5га, 54 иргэний төмс хүнсний ногооны 8,6га, 1 иргэний хөдөө аж ахуйн зориулалттай 5га, нийт 2478 нэгж талбар бүртгэгдээгүй байгаа буюу энэ нь нийт газар эзэмшигчдийн 9,1%-ийг эзэлж байгаа бөгөөд газрын төлбөрийг ойролцоогоор тооцож

үзэхэд 1 жилийн төлбөр нь 9,994,288 (есөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун наян найм) төгрөг, 2023, 2024 онуудад нийт 19,988,576 (арван есөн сая есөн зуун наян найман мянга таван зуун далан зургаа) төгрөгийг төлөх боломж алдагдсан байна. Системд мэдээлэл оруулаагүй байгаа нь Богд, Баянгол, Баян-Өндөр, Бүрд, Баруунбаян-Улаан сумдад газрын даамалгүй ажилласантай холбоотой гэсэн тайлбарыг мэргэжилтнүүд өгсөн. онд нийт 335 захирамжаар 1447 нэгж талбар буюу 1352 иргэн, 95 аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглахтай холбоотой захирамж гарчээ. Үүнээс: газар эзэмших эрх шинээр олгосон 123 захирамжийн 1076 нэгж талбар буюу 1011 иргэн, 65 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх шилжүүлсэн 144 захирамжийн 263 нэгж талбар буюу 253 иргэн, 10 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх сунгасан 21 захирамжийн 34 нэгж талбар буюу 26 иргэн, 8 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх хүчингүй болгох 19 захирамжийн 29 нэгж талбар буюу 22 иргэн 7 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх нэгтгэх 4 захирамжийн 9 нэгж талбар буюу 7 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллага, эзэмшил газрын хэмжээ, зориулалт өөрчлөх 24 захирамжийн 36 нэгж талбар буюу 33 иргэн, 3 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг газрын нэгдсэн системд бүрэн оруулсан.

2024 онд нийт 431 захирамжаар 1271 нэгж талбар буюу 1106 иргэн, 165 аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглахтай холбоотой захирамж гарчээ. Үүнээс: газар эзэмших эрх шинээр олгосон 95 захирамжийн 510 нэгж талбар буюу 454 иргэн, 56 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх шилжүүлсэн 188 захирамжийн 439 нэгж талбар буюу 400 иргэн, 39 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх сунгасан 56 захирамжийн 140 нэгж талбар буюу 126 иргэн, 14 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх хүчингүй болгох 11 захирамжийн 63 нэгж талбар буюу 54 иргэн 9 аж ахуйн нэгж, байгууллага, газар эзэмших эрх нэгтгэх 10 захирамжийн 10 нэгж талбар буюу 8 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллага, эзэмшил газрын хэмжээ зориулалт өөрчлөх 71 захирамжийн 109 нэгж талбар буюу 64 иргэн, 45 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг газрын нэгдсэн системд бүрэн оруулжээ.

2023, 2024 онуудын захирамжаар олгосон 2718 нэгж талбаруудын мэдээллийг газрын мэдээллийн нэгдсэн системээс татан ирүүлсэн дэлгэрэнгүй тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад 2023 онд шинээр эзэмшил газар олгогдсон 44 нэгж талбар, 2024 онд 99 нэгж талбар, нийт 143 нэгж талбараас 71 нэгж талбар дээр шинээр газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд цахим системд гэрээний нөхцөлөө зөвшөөрдөггүй, 1 нэгж талбар дээр хавсралт файлыг дутуу оруулсан, 6 нэгж талбар дээр иргэн, аж ахуйн нэгж татварын системд бүртгэлгүй, 5 нэгж талбар дээр газрын кадастрын системийн программын алдаанаас хамаарсан, 60 нэгж талбар дээр хөрөнгийн бүртгэлийн код үүсээгүй гэх шалтгаанаар ногдуулалт үүсээгүй байна. Хөрөнгийн бүртгэлийн код үүсгэхийн тулд газрын кадастрын мэдээллийн системээс татварын системрүү газрын даамрууд илгээж дунджаар ажлын 2 хоногт багтаж автоматаар код үүсдэгтэй боловч шалгалтын явцад эдгээр нэгж

талбарт хөрөнгийн бүртгэлийн код үүсээгүй нь тогтоогдсон ба код үүссэн эсэхэд газрын даамлууд эргэн хяналт хийдэггүй байдал ажиглагдлаа.

Үүнээс шалтгаалан дээрх 143 нэгж талбарт газрын төлбөрийн тооцоог ойролцоогоор тооцож үзэхэд 2023, 2024 онд нийт 3,305,560 (гурван сая гурван зуун таван мянга таван зуун жар) төгрөгийн газрын төлбөр орох боломж алдагдсан байна.

Шалгалтын хугацаанд 6216030296 нэгж талбарын дугаартай газар эзэмшигчийн гэрээ давхардаж, илүү нэхэмжлэх үүссэнийг засуулсан, 6216000299 нэгж талбарын дугаартай Газрын улаач ХХК-ийн 2023 оны нэхэмжлэх цуцлагдаж төлөгдөөгүй байсан 500,000 (таван зуун мянга) төгрөгийн газрын төлбөрийг 2025 он дээр нөхөн төлбөрийн нэхэмжлэх үүсгүүлсэн, газрын мэдээллийн кадастрын системд 2011 онд 6226002079 нэгж талбарын дугаартай 1 иргэний, 2013 онд 6204000719 нэгж талбарын дугаартай 1 иргэний, 2017 онд 6205000532 нэгж талбарын дугаартай 1 иргэний, 2019 онд 6203000668, 6209006743, 6209006741, 6209006740, 6209006748, 6209006747, 6209006759 нэгж талбарын дугааруудтай 7 иргэний, 2020 онд 6206001340 нэгж талбарын дугаартай 1 иргэний нийт 11 нэгж талбарын "өвөлжөө хаваржааны" зориулалттай газрын мэдээллийг кадастрын системд "өвөл хаврын бэлчээр" гэж буруу зориулалтаар оруулсныг залруулж, газрын төлбөрийг засуулж ажиллалаа.

Зам тээврийн хөгжлийн яамнаас 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 01/5435 дугаар бүхий албан бичгээр "Авто замын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон этгээд байна." гэж заасны дагуу Зам тээврийн хөгжлийн яаманд эзэмшүүлэх асуудлыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хамтран ажиллах чиглэлийг аймгийн Засаг дарга нарт өгсөний дагуу улсын чанартай хатуу хучилттай зам дайран өнгөрч буй Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан, Хужирт сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч ажилласан боловч Нарийнтээл, Хайрхандулаан сумаас бусад сум нь холбогдох шийдвэрийг гаргаагүй байна.

Нарийнтээл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/218 дугаар захирамжаар 52км авто замын зурвас газрын зориулалтаар газар эзэмшүүлэх эрхийг Зам тээвэр хөгжлийн яаманд олгосон шийдвэрийг гаргаж, Нарийнтээл сум газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн 2024 онд 52 км замд ногдох 390,471 (гурван зуун ерэн мянга дөрвөн зуун далан нэг) төгрөгийн газрын төлбөрийг ногдуулсан боловч төлөгдөөгүй байгаа.

Хайрхандулаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/154 дүгээр захирамжаар 63 км авто замын зурвас газрын зориулалтаар газар эзэмшүүлэх эрхийг Зам тээвэр хөгжлийн яаманд олгосон шийдвэрийг гаргасан боловч Хайрхандулаан сум мэдээллийн сандаа замын трассыг оруулахаар алдаа заагаад байгаа гэх шалтгаанаар одоогоор оруулаагүй байна.

Нарийнтээл сумаас бусад 7 сумын нийт 220,6 км улсын чанартай хатуу хучилттай авто замд жилд 1,654,500 (нэг сая зургаан зуун тавин дөрвөн мянга таван зуу) төгрөгийн газрын төлбөрийг ногдуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Имперо майнинг, Өгөөмөр-Өргөө, Баярсгоулд, Аум-Алт, Галт-Үнэг, Эм Эс БЭЛ майнинг ХХК, Баянтээг ХК нийт 7 аж ахуйн нэгж байгаагаас 5 аж ахуйн нэгж, байгууллага нь газрын төлбөрт 2023 онд 199,653,443 (нэг зуун ерэн есөн сая зургаан зуун тавин гурван мянга дөрвөн зуун дөчин гурав) төгрөг, 2024 онд 159,232,275 (нэг зуун тавин есөн сая хоёр зуун гучин хоёр мянга хоёр зуун далан тав) төгрөгийн газрын төлбөрийг төлсөн. Газрын төлбөр төлөөгүй 2 аж ахуйн нэгж болох Тарагт суманд үйл ажиллагаа явуулж байгаа Галт-Үнэг ХХК нь 2023 онд 9,12га, 2024 онд 3,71га газарт ашиглалт явуулсан, Зүүнбаян-Улаан суманд 2024 оны 06 дугаар сараас үйл ажиллагаа явуулж байгаа Эм Эс БЭЛ майнинг ХХК нь 5га газарт ашиглалт явуулсан байгаа боловч тухайн сумдын даамлууд газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгаж ИТХуралд оруулдаг боловч тухайн газруудыг төлөвлөгөөнөөс хасаж баталдагаас үүдэн одоогоор газрын төлбөр ногдуулалт хийгдээгүй байна. Үүнээс үүдэн ойролцоогоор тооцож үзэхэд Тарагт сум 2023, 2024 онд 20,528,000 (хорин сая таван зуун хорин найман мянга) төгрөгийн, Зүүнбаян-Улаан сум 2024 онд 8,000,000 (найман сая) төгрөгийн газрын төлбөрийн орлого олох боломж алдагдсан байна.

Өглөг, авлагын тооцоолол, бүртгэл, тайлагналт:

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн өр, авлагын үлдэгдэлийг үнэн зөв мэддэг, түүнийг бүргэдэг, тайлагнадаг, тооцоо хийдэг байгууллага байхгүй байна.

Мөн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас газар зохион байгуулалттай холбоотой 10 төрлийн тайлан гардаг ба тэдгээрийн ГНСТ-1,2,3,4,8,9,10 тайлангуудыг гараар гаргадаг, ГНСТ-5,6,7 тайлангуудыг системээр гаргадаг байна.

Татварын ерөнхий газраас ирүүлсэн судалгаанд газрын төлбөрийн авлагыг 2023 онд 434,199,800 (дөрвөн зуун гучин дөрвөн сая нэг зуун ерэн есөн мянга найман зуу) төгрөг, 2024 онд 688,670,200 (зургаан зуун наян найман сая зургаан зуун далан мянга хоёр зуу) төгрөг гэж ирүүлсэн байхад ГНСТ-8 тайланд газрын төлбөрийн авлагыг 2023 онд 316,994,900 (гурван зуун арван зургаан сая есөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуу) төгрөгөөр тусгаж, 117,204,900 (нэг зуун арван долоо сая хоёр зуун дөрвөн мянга есөн зуу) төгрөгөөр дутуу, 2024 онд 27,446,000 (хорин долоон сая дөрвөн зуун дөчин зургаан мянга) төгрөгөөр тусгаж, 661,224,200 (зургаан зуун жаран нэг сая хоёр зуун хорин дөрвөн мянга хоёр зуу) төгрөгөөр дутуу тайлагнажээ.

Газрын алба нь газрын төлбөрийн үлдэгдлийг ГНСТ-8 тайланд (гараар гаргадаг) тусгаж байгаа боловч уг тайланд үлдэгдлийг зөвхөн тухайн оны төлбөл зохих дүнгээс хөөж гаргадагаас үлдэгдэл нь өссөн дүнгээр гардаггүй.

Ингэж зөрсөний шалтгааныг тодруулах үүднээс ГНСТ-8 тайлангийн дэлгэрэнгүйг газрын мэдээллийн нэгдсэн системээс 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тасалбар болгосон татан ирүүлсэн хүчинтэй гэрээ бүхий 14646 нэгж талбарын дэлгэрэнгүй тайлангийн мэдээллийг газрын нэгдсэн системийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах ажлыг хийлээ. Ингэхдээ шалгалтын хугацаанд бүгдийг тулган баталгаажуулах боломжгүй тул хамгийн том сумаас санамсаргүй түүврийн аргаар 302 нэгж талбарыг, хамгийн жижиг сум буюу Өлзийт сумын 390 нэгж талбарыг 100% хамруулан системд оруулсан мэдээллээс газрын төлбөр ногдуулалт, төлөлт, газрын төлбөрийн үлдэгдлийг нэгж талбар бүрээр нэг бүрчлэн тулгалтыг хийхэд тайлант хугацаанд төлбөл зохих нийт төлбөр, тайлант хугацаанд төлсөн төлөлт, газрын төлбөрийн үлдэгдэл дүн зөрүүтэй гарлаа. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

(мян.төг)

Д/д	Сумын нэр		2023 он			2024 он		
			Тайлант хугацаанд Төлбөл зохих нийт төлбөр	Тайлант хугацаанд төлсөн нийт төлбөр	Нийт үлдэгдэл төлбөр	Төлбөл зохих нийт	Тайлант хугацаанд төлсөн нийт төлбөр	Нийт үлдэгдэл төлбөр
1	Арвайхээр	Системээс татан ирүүлсэн тайлан	239955,2	64498,9	174856,3	282162,1	186086,1	96076,0
		Системтэй Тулгалт хийхэд	235722,2	68030,5	167691,7	328218,8	192777,8	135441,0
		Зөрүү	4233,0	-3531,6	7164,6	-46056,7	-6691,7	-39365,0
2	Өлзийт	Системээс татан ирүүлсэн тайлан	15526,1	5849,5	9676,6	12434,5	1649,2	10785,3
		Системтэй тулгалт хийхэд	8644,1	4564,0	4080,1	9944,1	2724,2	7219,9
		Зөрүү	6822,0	1285,5	5596,5	2490,4	-1075,0	3565,4

Дээрх хүснэгтээс харахад тайлант хугацаанд төлбөл зохих дүн, тайлант хугацаанд төлсөн дүн, газрын төлбөрийн авлага бүгд зөрүүтэй байгаа нь системд газрын төлбөрийн төлөлт бүр бүрэн татагддаггүйгээс үлдэгдэл буруу үүсдэг, урд оны илүү, дутуу төлөлт системд тусгагдсан байгаа боловч ГНСТ-8 тайлангийн дэлгэрэнгүйд алдаатай дүнгээр татагддаг нөхцөл байдал тогтоогдлоо.

Тухайлбал: Өлзийт сумын зарим газар эзэмшигчдийн оны дундуур буюу 05, 06, 11, 12 дугаар саруудын төлөлтүүд дутуу татагдсан, ихэвчлэн 12 сарын төлөлт татагддаггүйгээс газрын төлбөрийн үлдэгдэл зөрүүтэй гардаг нь тулган баталгаажуулах үед тогтоогдож, өмнөх онуудын газрын төлбөрийн авлагыг мэргэжилтэнтэй хамтран тооцоолол хийж, урд онуудын илүү, дутууг тооцсон, зарим мэдээллийг Газар, зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас асууж, тодруулж үлдэгдлийг зөв болгон тусгууллаа. Ингэж

мэдээллүүд буруу, дутуу татагдаж байгааг системийн хөгжүүлэлт бүрэн гүйцэд болоогүй байгаатай холбоотой гэх тайлбарыг өгсөн.

Мөн газар эзэмшигчийн гэрээний хугацаа тайлант онд дуусч гэрээгээ сунгаагүй тохиолдолд дараа онд газрын төлбөрийн ногдол, нэхэмжлэх нь үүсдэггүй, гэрээг сунгасны дараа үүсээгүй үлдсэн газрын төлбөрийн ногдлыг нөхөн төлбөрөөр үүсгэн гараар системд оруулж, газрын төлбөрийг төлүүлдэг, газар эзэмшигч нь газраа бусдад шилжүүлэхдээ өмнөх онуудын төлбөрийн үлдэгдлээ төлж барагдуулдаг боловч шилжүүлж өгсөн ондоо 1 нэгж талбар дээр 2 эзэмшигчтэй болсноор системд харагддаг, зарим улирлын ногдол болон нэхэмжлэх нь системд дутуу орсон, орхигдсоноос газрын төлбөр төлөгдөхгүй үлддэг зэрэг асуудал үүсдэг байна.

Өлзийт суманд өвөлжөө, хаваржааны төлбөр төлөөгүй 2020 оноос хойш 28 газар эзэмшигчийн 588,000 (таван зуун наян найман мянга) төгрөг, 2021 оноос хойш 16 газар эзэмшигчийн 268,800 (хоёр зуун жаран найман мянга найман зуу) төгрөг, Арвайхээр сумын түүвэрт хамрагдсан газар эзэмшигчдээс 2023-2024 оны газрын төлбөрийг төлөөгүй 23 эзэмшигчийн 11,887,216 (арван нэг сая найман зуун наян долоон мянга хоёр зуун арван зургаа) төгрөг, 3-аас дээш жилийн төлбөрийг төлөөгүй 45 эзэмшигчийн 65,994,310 (жаран таван сая есөн зуун ерэн дөрвөн мянга гурван зуун арав) төгрөг байгаа зэрэг нь сумдын газрын даамал, татварын улсын байцаагч нар тухайн жил жилдээ газар эзэмшигч бүрээр газрын төлбөрийн өр, авлагаа тооцоо нийлж, газрын төлбөрийн дутууг насжилтаар нь тооцон өр, авлагаа барагдуулах талаар санал санаачлагатай ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Газрын нэгдсэн системээс аймгийн нийт хүчинтэй гэрээтэй газар эзэмшигчдийн тухайн жилд төлөх газрын нийт төлбөрөөс төлөгдсөн дүн болон газрын төлбөрийн илүү, дутууг нэгтгэж харах боломжгүй байна.

Газрын төлбөрийн үлдэгдэл системд буруу, дутуу тооцогдож явдаг, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн тайланд (ГНСТ-8) өмнөх онуудын авлага, өглөг тусгагддаггүй, тайлант оноор тусгадаг, татварын газарт тухайн онд үүссэн нийт татварын ногдол харагддаггүй, газрын албатай тооцоо нийлдэггүй, төрийн сантай зөвхөн газрын төлбөрийн орлогын дүнг тооцоо нийлж ажилладаг, сумдын болон аймгийн нэгдсэн санхүүгийн тайланд газрын төлбөрийн орлого нь тусгагддаг боловч өглөг, авлага нь тусгагддаггүй, газрын алба газрын төлбөрийн авлага, өглөгийг сумдын газрын даамлуудтай тооцоо нийлж ажилладаггүй зэрэг шалтгааны улмаас газрын төлбөрийн авлагын барагдуулалт хангалтгүй байна.

Татварын ерөнхий газрын мэдээллээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 688,670,300 (зургаан зуун наян найман сая зургаан зуун далан мянга гурван зуу) төгрөгийн авлагатай гэсэн мэдээ байгаа боловч сум болон аймгийн санхүүгийн тайлан болон ГНСТ-8 тайланд тусгагдаагүй байгаагаас үзэхэд газрын төлбөрөөс орж ирэх орлого алдагдсаар байгаа нь харагдаж байна.

4.3. Газрын төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байдал;

Газрын төлбөрийн орлого төлөвлөлт, гүйцэтгэл:

Газрын төлбөрийн орлогыг төлөвлөхдөө урд оны үлдэгдлээс хэдийг төлүүлэх, тайлант оны ногдлоос хэдийг төлүүлэх гэсэн байдлаар задалж төлөвлөдөггүй зөвхөн урд оны орлогын гүйцэтгэлд үндэслэн бөөн дүнгээр төлөвлөдөг. Ингэхдээ газрын албанаас тайлант онд ногдуулсан төлбөрийн 80% төлөгдөнө гэсэн санал өгдөг ба үүнийг жил бүр нэмэгдүүлж 2025 оны төсөвт 100% төвлөрүүлэхээр тооцож төлөвлөсөн байна.

2023 онд 775,999.900 (долоон зуун далан таван сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн төлөвлөгөөтэй ажилласнаас 829,687,100 (найман зуун хорин есөн сая зургаан зуун наян долоон мянга нэг зуу) төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөний биелэлт 106,9%, 2024 онд 916.700.000 (есөн зуун арван зургаан сая долоон зуун мянга) төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажилласнаас 1,020,831,800 (нэг тэрбум хорин сая найман зуун гучин нэгэн мянга найман зуу) төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөний биелэлт 123%-иар тус тус биелэсэн. Гүйцэтгэлийг дүгнэхдээ мөн урд оны үлдэгдлээс, тайлант оны ногдлоос хэд төлөгдсөн гэсэн тооцоолол хийдэггүй байна.

Татварын гарзаас ирүүлсэн судалгаанд үндэслэн тооцоо хийхэд 2023 онд орсон орлогын 2,9 хувь буюу 25,387,021 (хорин таван сая гурван зуун наян долоон мянга хорин нэг) төгрөг, 2024 онд орсон орлогын 1,5 хувь буюу 15,348,281 (арван таван сая гурван зуун дөчин найман мянга хоёр зуун наян нэг) төгрөг нь тус тус урд орны үлдэгдлээс төлөгдсөн төлбөр байна.

4.4. ГХБХБГазрын өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, үр дүн;

2023 онд өөрийн орлого 95,000,000 (ерэн таван сая) төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 95,072,610 (ерэн таван сая далан хоёр мянга зургаан зуун арав) төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Барилгын техник хяналтын орлогын бүрдүүлэлтийг гүйцэтгэлээр харуулбал:

Хүснэгт-1

Барилгын техник хяналт орлого бүрдүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үүнээс:				
			Газрын үйлчилгээний орлого	Барилга хөгжлийн төв ТӨААТҮГазар	Газрын суурь үнз/газар сунгах/	Барилгын техник хяналтын зардал /Орон нутгаас/	Барилгын техник хяналтын зардал /Хувийн/
	95,000,000	95,072,611	38,715,875	15,397,408	20,000,000	19,559,650	1,399,680

Барилгын техник хяналтын зардлын зарцуулалтыг гүйцэтгэлээр харуулбал:

Хүснэгт-2

Барилгын техник хяналтын зардлын зарцуулалт	Орсон орлого	Заруулалт	Үүнээс:				
			гэрээт цалин/шимтгэл	шатахуун	томилолт	сургалт	барилгын хувийн хэрэг
	95,072,611	94,999,699	21,069,652	16,936,718	45,785,000	1,300,000	552,900

Мөн Өв.ГХБХБГазрын орлогын 100100029002 тоот дансанд нийт 748,506,406 (долоон зуун дөчин найман сая таван зуун зургаан мянга дөрвөн зуун зургаа) төгрөгийн орлого төвлөрсөнөөс дуудлага худалдааны дэнчин 83,133,573 (наян гурван сая нэг зуун гучин гурван мянга таван зуун далан гурав) төгрөг, данс андуурсан орлого 2,170,360 (хоёр сая нэг зуун далан мянга гурван зуун жар) төгрөгийг буцаан төвлөрүүлж, газрын дуудлага худалдааны орлого 562,660,739 (таван зуун жаран хоёр мянга зургаан зуун жаран мянга долоон зуун гучин ес) төгрөгийг аймгийн ерөнхий орлогын 100100000967 тоот дансанд, газрын үйлчилгээний орлого 23,750,000 (хорин гурван сая долоон зуун тавин мянга) төгрөгийг Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 100900029004 тоот, газрын дуудлага худалдааны орлогоос 31,401,915 (гучин нэгэн сая дөрвөн зуун нэг мянга есөн зуун арван тав) төгрөгийг байгууллагын үндсэн 100100029001 тоот дансанд, 45,389,819 (дөчин таван сая гурван зуун наян есөн мянга найман зуун арван ес) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн 100100029002 тоот дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3

№	Үзүүлэлт	Орлого	Зарлага
1	Дуудлага худалдааны орлого	562,660,739	
2	Дэнчингийн буцаах орлого	83,133,573	
3	Ташаарсан орлого	2,170,360	
4	ГЗБГЗ зүйн үйл ажиллагааны баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний орлого	35,687,669	
5	Газрын суурь үнийн орлого	64,854,065	
	ДҮН	748,506,406	748,506,406
6	Дуудлага худалдааны дэнчин буцаан олгосон		83,133,573
7	Данс андуурсан орлого буцаан олгосон		2,170,360
8	Аймгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн		562,660,739
9	Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төвлөрүүлсэн		23,750,000
10	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод тооцож үйл ажиллагааны дансанд төвлөрүүлсэн		31,401,915
11	Төсвийн байгууллагын нэмэлт үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн		45,389,819

Батлагдсан төсөв, санхүүжилт: 2023 онд улсын төсвөөс 985,817,700 (есөн зуун наян таван сая найман зуун арван долоон мянга долоон зуу) төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 95,000,000 (ерэн таван сая) төгрөг нийт 1,080,817,700 (нэг тэрбум наян сая найман зуун арван долоон мянга долоон зуу) төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 985,817,700 (есөн зуун наян таван сая найман зуун арван долоон мянга долоон зуу) төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 95,072,610 (ерэн таван сая далан хоёр мянга зургаан зуун арван) төгрөг, нийт 1,080,890,310 (нэг тэрбум наян сая найман зуун ерэн мянга гурван зуун арав) төгрөгийн орлого орж 1,070,276,606 (нэг тэрбум далан сая хоёр зуун далан зургаан мянга зургаан зуун зургаа) төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 10,613,704 (арван сая зургаан зуун арван гурван мянга долоон зуун дөрөв) төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Зардлыг нэр төрөл тус бүрээр дараах хүснэгтэд задлан харуулбал:

Хүснэгт-4

№	Нэр төрөл	2023 он			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хуви
1	Улсын төсвийн санхүүжилт	985,817,700	985,817,700	-	100%
2	Өөрийн орлого	95,000,000	95,072,610	72,610	100%
	ОРЛОГЫН ДҮН	1,080,817,700	1,080,890,310		99%
3.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	842,548,300	832,049,367	10,498,933	98%
3.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,318,600	105,317,798	802	99%
3.3	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	18,809,100	18,809,100	-	100%
3.3	Хангамж, бараа материалын зардал	4,562,100	4,561,092	1,008	100%
3.4	Норматив зардал	134,900	134,900	-	100%
3.5	Урсгал засвар	328,400	328,400	-	100%
3.6	Томилолт, зочны зардал	2,789,600	2,758,950	30,650	98%
3.7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,577,300	8,577,300	-	98%
3.8	Бараа үйлчилгээний бусад зардал	95,000,000	94,999,699	301	100%
3.9	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,749,400	2,740,000	9,400	98%
	ЗАРДЛЫН ДҮН		1,070,276,606	10,613,704	

Нэмэлт санхүүжилт: 2023 онд 239,008,916 (хоёр зуун гучин есөн сая найман мянга есөн зуун арван зургаа) төгрөгийн орлого орж, 190,340,649 (нэг зуун ерэн сая гурван зуун дөчин мянга зургаан зуун дөчин ес) төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 394,977 (гурван зуун ерэн дөрвөн мянга есөн зуун далан долоо) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-5

№	Үзүүлэлт	Орлого
1	Барилгын техник хяналт (Орон нутгаас)	68,154,650
2	Барилгын техник хяналт (Хувийн)	37,453,407
3	Эргэлтийн цэгийн орлого	1,974,000
4	Лабораторийн орлого	4,125,840
5	Газрын үйлчилгээний орлого	127,301,019
	ОРЛОГЫН ДҮН	239,008,916
1	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,873,312
2	Бичиг хэрэг	9,143,076
3	Тээвэр шатахуун	18,853,392
4	Шуудан холбоо, интернетийн төлбөр	598,451
5	Ном хэвлэл	126,000
6	Бага үнэтэй түргэн элэгдэх	3,933,324
7	Багаж техник хэрэгсэл	36,041,715
8	Урсгал засвар	26,724,950
9	Томилолтын зардал	61,820,000
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,701,000
11	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх (сургалтын зардал)	18,125,000
12	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000
13	Барилгын техник хяналтын зардал	4,100,000
	ЗАРЛАГЫН ДҮН	190,340,649
1	Үндсэн дансанд төвлөрүүлсэн (үндсэн үйл ажиллагааны орлого)	48,273,290

2	Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн	394,977
---	-------------------------------	---------

2024 онд өөрийн орлого 125,000,000 (нэг зуун хорин таван сая) төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 119,147,405 (нэг зуун арван есөн сая нэг зуун дөчин долоон мянга дөрвөн зуун тав) төгрөг бүрдүүлж, 119,071,795 (нэг зуун арван есөн сая далан нэгэн мянга долоон зуун ерэн тав) төгрөгийг зарцуулж, 75,610 (далан таван мянга зургаан зуун арав) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 95,3 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлын зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-6

№	Үзүүлэлт	Орлого	Зарлага
1	газрын хэмжилт, зураг, үйлчилгээний бусад орлого	14,578,730	
2	кадастрын орлого	9,568,675	
3	барилгын техник хяналтын зардал /орон нутгаас/	95,000,000	
	ДҮН	119,147,405	119,071,795
4	Томилолтын зардалд		76,080,000
5	Шатахууны зардал		22,801,475
6	Сургалтын зардалд		4,896,000
7	Лабораторийн тоног төхөөрөмж		10,506,600
8	Лабораторийн багаж хэрэгсэл		1,678,420
9	Нормын хувцас		2,870,000
10	Барилгын техник хяналтын зардал		209,000
11	ГЗГЗЗҮйлчилгээний, БТХяналтын шуудан, холбооны зардал		30,300

Батлагдсан төсөв, санхүүжилт: 2024 онд улсын төсвөөс 1,478,000,300 (нэг тэрбум дөрвөн зуун далан найман мянга гурван зуу) төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 125,000,000 (нэг зуун хорин таван сая) төгрөг нийт 1,603,000,300 (нэг тэрбум зургаан зуун гурван мянга гурван зуу) төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,478,000,300 (нэг тэрбум дөрвөн зуун далан найман мянга гурван зуу) төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажилагааны орлого 119,147,405 (нэг зуун арван есөн сая нэг зуун дөчин долоо мянга дөрвөн зуун тав) төгрөг, нийт 1,597,147,705 (нэг тэрбум таван ерэн долоон сая нэг зуун дөчин долоо мянга долоон зуун тав) төгрөгийн орлого олж, 1,556,133,654 (нэг тэрбум таван зуун тавин зургаан сая нэг зуун гучин гурван мянга зургаан зуун тавин дөрөв) төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 41,014,051 (дөчин нэг сая арван дөрвөн мянга тавин нэг) төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Гүйцэтгэлийг нэр төрөл тус бүрээр дараах хүснэгтэд задлан харуулав.

Хүснэгт-7

№	Нэр төрөл	2023 он			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Улсын төсвийн санхүүжилт	1,478,000,300	1,478,000,300	-	100%
2	Өөрийн орлого	125,000,000	119,147,405	-5,852,595	95,3%
	ОРЛОГЫН ДҮН	1,603,000,300	1,597,147,705		97%
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,135,591,000	1,092,149,210	43,441,790	96,2%

4	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,220,800	139,830,999	3,389,802	97,6%
5	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	18,451,700	18,451,700	-	100%
6	Хангамж, бараа материалын зардал	4,475,400	4,475,070	330	100%
7	Норматив зардал	132,300	132,000	300	100%
8	Эд хогшил, урсгал засварын зардал	322,200	322,200	-	100%
9	Томилолт, зочны зардал	2,736,600	2,722,500	14,100	99,5%
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,925,300	7,925,300	-	100%
11	Бараа үйлчилгээний бусад зардал	124,430,000	124,429,976	24	99,9%
12	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,697,200	2,697,200	-	
13	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,705,200	23,684,900	20,300	98%
14	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	139,312,600	139,312,600		100%
ЗАРДЛЫН ДҮН			1,556,133,654		

Нэмэлт санхүүжилт: 2024 онд 500,504,990 (таван зуун сая таван зуун дөрвөн мянга есөн зуун ер) төгрөгийн орлого орж, 496,273,010 (дөрвөн зуун ерэн зургаан сая хоёр зуун далан гурван мянга арав) төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 4,231,980 (дөрвөн сая хоёр зуун гучин нэгэн мянга есөн зуун наа) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-В

№	Үзүүлэлт	Орлого	Зарлага
1	Барилгын техник хяналтын зардал (Орон нутгаас)	354,133,400	
2	Барилгын техник хяналтын зардал (Хувийн)	49,899,720	
3	Барилга хөгжлийн төв ТӨААТҮГАЗАР-ын 2023 оны авлага	55,006,569	
4	Орон нутгаас олгож буй (орон нэмэгдэл 20 хувь)	39,467,341	
5	Газрын хэмжилт, зураг, үйлчилгээний бусад орлого	1,197,960	
6	ГЗБГЗЗЕГазар	800,000	
	ДҮН	500,504,990	500,504,990
7	Цалин хөлс (орон нутгийн нэмэгдэл)		33,893,197
8	Гэрээт ажилтны цалин		55,972,878
9	Нийгмийн даатгалын шимтгэл		11,010,225
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		13,106,096
11	Бичиг хэрэг		8,605,300
12	Тээвэр шатахуун		1,800,000
13	Шуудан холбоо, интернетийн төлбөр		587,470
14	Ном хэвлэл		665,000
15	Хог хаягдал зайлуулах		360,000
16	Бага үнэтэй түргэн элэгдэх		2,999,912
17	Багаж техник хэрэгсэл		5,581,238
18	Урсгал засвар		25,039,520

19	Томилолтын зардал	21,179,000
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,784,340
21	Бараа үйлчилгээний бусад зардал	59,639,970
22	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх (сургалтын зардал)	22,649,464
23	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,199,400
24	Хөрөнгийн зардал (автомашин, тоног төхөөрөмж худалдан авсан)	227,200,000
25	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,231,980

4.5. Өр авлагын барагдүүлалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;

2023 онд харилцагч байгууллагуудад өргүй гарсан ба Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГазар захиалгаар тус онд Хужирт, Бат-Өлзий сумдын инженерийн шугам сүлжээний ажлын явцад 21,404,614 (хорин нэгэн сая дөрвөн зуун дөрвөн мянга зургаан зуун арван дөрөв) төгрөгийн, Хархорин сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дотор засварт 1,434,672 (нэг сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун далан хоёр) төгрөгийн, Хужирт сумын Ерөнхий боловсролын сургуулийн сантехникийн засварын явцад 1,575,905 (нэг сая таван зуун далан таван мянга есөн зуун тав) төгрөгийн, Уянга сумын сургуулийн засварын үйл явцад 1,040,591 (нэг сая дөчин мянга таван зуун ерэн нэг) төгрөгийн, Хархорин сумын 2 дугаар сургуулийн засварын явцад 377,811 (гурван зуун далан долоо мянга найман зуун арван нэг) төгрөгийн, Уянга, Хужирт сумдын сумын хөгжил инженерийн дэд бүтэц төсөлийн явцад 22,649,414 (хорин хоёр сая зургаан зуун дөчин есөн мянга дөрвөн зуун арван дөрөв) төгрөгийн, Уянга сумын 1 дүгээр сургуулийн засварын явцад 260,148 (хоёр зуун жаран мянга нэг зуун дөчин найм) төгрөгийн, Хайрхандулаан сумын дотуур байрны дээвэр засварын явцад 304,405 (гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун тав) төгрөгийн, Нарийнтээл, Баянтээг, Төгрөг, Гучин-Ус Өлзийт, Баян-Өндөр, Нарийнтээл, Хужирт, сумдын ариун цэврийн байгууламжийн явцад 5,643,896 (таван сая зургаан зуун дөчин гурван мянга найман зуун ерэн зургаа) төгрөгийн, Хархорин сумын сургуулийн гал тогоо засварын явцад 207,856 (хоёр зуун долоон мянга найман зуун тавин зургаа) төгрөгийн, Сант сумын ЕБС-ийн 100 хүүхдийн дотуур байрны ажлын явцад 107,255 (нэг зуун долоо мянга хоёр зуун тавин тав) төгрөгийн барилгын техникийн хяналт хийлгэж, нийт 55,006,568 (тавин таван сая зургаан мянга таван зуун жаран найм) төгрөгийн авлагатай гарсныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгажээ.

2024 онд харилцагч байгууллагуудад өргүй гарсан ба "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГазрын захиалгаар тус онд Бат-Өлзий, Уянга сумдад СТ инженерийн шугам сүлжээний ажлын явцад 41,399,207 (дөчин нэгэн сая гурван зуун ерэн есөн мянга хоёр зуун долоо) төгрөгийн, Сант, Зүүнбаян-Улаан, Уянга, Нарийнтээл, Өлзийт, Баянгол, Хархорин, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Тарагт Арвайхээр Бат-Өлзий Хужирт сумдын ариун цэврийн байгууламжийн явцад 34,855,476 (гучин дөрвөн сая найман зуун тавин тав мянга дөрвөн зуун далан зургаа) төгрөгийн, Хужирт сумын инженерийн шугам сүлжээний ажлын

явцад 4,603,420 (дөрвөн сая зургаан зуун гурав мянга дөрвөн зуун хорь) төгрөгийн, Хужирт сумын хөгжил, инженерийн дэд бүтэц хангамжийн төслийн явцад 7,462,166 (долоон сая дөрвөн зуун жаран хоёр мянга нэг зуун жаран зургаа) төгрөгийн барилгын техник хяналт хийж, нийт 88,320,271 (наян найман сая гурван зуун хорин мянга хоёр зуун далан нэг) төгрөгийн авлагатай гарснаас ГХБХБГ-ийн №639 албан бичгийн дагуу сэтгүүлийн тооцоо 1,250,000 (нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг суутгаж нийт үлдэгдэл 87,070,271 (наян долоон сая далан мянга хоёр зуун далан нэг) төгрөгийн авлагатай гарсныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгажээ.

4.6. Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт;

Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр баталсан 03 дугаар удирдамж, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр баталсан 29/06 дүгээр удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019, 2020 онуудын санхүүгийн үйл ажиллагаа, газар эзэмшигч, ашиглагчийн судалгаанд үндэслэн газрын төлбөр тогтоолт, ногдуулалтыг газрын кадастрын мэдээллийн систем, татварын нэгдсэн системд хэрхэн бүртгэж байгаад хяналт шалгалт хийхэд анхан шатны баримттай холбоотой 3,286,000 (гурван сая хоёр зуун наян зургаан мянга) төгрөг, зориулалт бус зарцуулалт 7,410,200 (долоон сая дөрвөн зуун арван мянга хоёр зуу) төгрөг, газрын төлбөр ногдуулалттай холбоотой 25,947,000 (хорин таван сая есөн зуун дөчин долоон мянга) төгрөг, нийт 36,643,200 (гучин зургаан сая зургаан зуун дөчин гурван мянга хоёр зуу) төгрөгийн зөрчил илэрч, шалгалтын хугацаанд газрын төлбөр ногдуулалттай холбоотой зөрчлийг төлөгдөөгүй онуудын газрын нэхэмжлэхийг зөв тооцуулан засах арга хэмжээг авахуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 8 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 811 дугаар албан бичгээр ирүүлж алдаа зөрчил арилган ажиллаж байгаа ч газрын кадастрын системд 2478 нэгж талбарын мэдээлэл огт оруулаагүй албан шаардлагын биелэлт 80% биелэгдсэн байна.

Сангийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн СХШХ/07 дүгээр удирдамж, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр баталсан 29/12 дугаар удирдамжуудын дагуу Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2022, 2023 онуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө ногдуулсан төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байдлыг шалгахад 2022 онд 11752, 2023 онд 14066 иргэн, байгууллагуудын газар эзэмшиж, ашиглаж байгаагаас Баян-Өндөр сумын худалдаа, нийтийн үйлчилгээний газруудын 1кв.м төлбөрийг 10 (арав) төгрөгөөр бус 20 (хорь) төгрөгөөр илүү тооцсон, Өлзийт сумын газар тариалангийн 8 газрын 1 кв.м төлбөрийг 0.039 (тэг бүхэл мянганы гучин ес) төгрөгөөр буруу тооцсон зэрэг зөрчил илэрч шалгалтын хугацаанд системд буруу оруулсан 38 газар эзэмшигчийн мэдээллийг шинэчлүүлж, газрын төлбөр 4,856 (дөрвөн мянга найман зуун тавин зургаа) төгрөг илүү, 675,627 (зургаан зуун

далан таван мянга зургаан зуун хорин долоо) төгрөг дутуу ногдсон. Баян-Өндөр, Өлзийт, Хархорин сумдад илэрсэн зөрчлүүдийг арилгуулж, 15 газар эзэмшигчийн газрын зориулалт, төлбөрийг дахин нягтлан шалгаж мэдээллийг үнэн зөв болгуулахаар аймгийн ГХБХБГазарт улсын байцаагчийн 3 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 615 дугаар албан бичгээр албан шаардлагын биелэлтийг ирүүлсэн боловч 15 газар эзэмшигчийн 3 газар эзэмшигчийн мэдээлэл засагдаж, бусад 12 газар эзэмшигчийн мэдээлэл засагдаагүй албан шаардлагын биелэлт 20 хувьтай байна.

2021, 2022 онд аймгийн Дотоод аудитын хорооноос газрын төлбөр ногдуулалтыг газар эзэмшигч нэг бүрээр тулган шалгаж алдаа зөрчлийг арилган ногдуулалтыг үнэн зөв хийгдэх боломжийг бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргад үүрэг болгож, биелэлтийг газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж бүрээр дахин нягтлан шалгахад газар шинээр эзэмшигчийг газрын кадастрын системд бүртгээгүй, зориулалт буруу орсноос газрын төлбөр ногдуулалт илүү, дутуу тооцогдсон зөрчил дахин давтан гарсаар байна.

4.7.Санхүүгийн үйл ажиллагааны явц, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт:

Хөрөнгийн бүртгэл, хөтлөлт:

2023 оны эхэнд 895,750,573 (найман зуун ерэн таван сая долоон зуун тавин мянга таван зуун далан гурав) төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тус онд БСБ коммерс ХХК-иас 1,649,700 (нэг сая зургаан зуун дөчин есөн мянга долоон зуу) төгрөгийн 2 ширхэг Dell дэлгэц, 3,299,900 (гурав сая хоёр зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн суурин компьютер 1 ширхэг, 4,699,900 (дөрвөн сая зургаан зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн 3 үйлдэлт хэвлэгч принтер, Пи Си Молл-оос 2,399,900 (хоёр сая гурван зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн таблет, Өвөрхангай цахим сүлжээ ХХК-иас 3,792,315 (гурван сая долоон зуун ерэн хоёр мянга гурван зуун арван тав) төгрөгийн зөөврийн компьютер, 700,000 (долоон зуун мянга) төгрөгийн 3 үйлдэлт принтер, 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийн процессор, Азийн мөнгөн булаг ХХК-иас 770,000 (долоон зуун далан мянга) төгрөгийн хайрга дайрганы бутрагдалтын цилиндр, Өрнөх уран ХХК-иас 8,040,000 (найман сая дөчин мянга) төгрөгийн принтер 12 ширхэг, Энх элком ХХК-иас 1,500,000 (нэг сая тавин зуун мянга) төгрөгийн скайнер, 4,526,000 (дөрвөн сая таван зуун хорин зургаа мянга) төгрөгийн компьютер 1 ширхэг, нийт 33,577,715 (гучин гурван сая таван зуун далан долоо мянга долоон зуун арван тав) төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн "Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 126 дугаар тогтоолоор 1,490,099 (нэг сая дөрвөн зуун ерэн мянга ерэн ес) төгрөгийн 2 ширхэг компьютер, 11 нэр төрлийн 2,171,003 (хоёр сая нэг зуун далан нэгэн мянга гурав) төгрөгийн тавилга эд хогшил нийт 3,664,102 (гурван сая зургаан зуун жаран дөрвөн мянга нэг зуун

хоёр) төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч хөрөнгөд бүртгэн, хөрөнгийн дахин үнэлгээгээр 6 нэр төрлийн 2,012,717 (хоёр сая арван хоёр мянга долоон зуун арван долоо) төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн оны эцэст 935,005,108.2 (есөн зуун гучин таван сая таван мянга нэг зуун найм аравны хоёр) төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт-9

№	Үзүүлэлт	2023 он				Эцсийн үлдэгдэл
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			
			Төсвийн хөрөнгөөр	Шилжүүлэн авсан	Дахин үнэлгээний нэмэгдэл	
1	Барилга байгууламж	588,207,202				588,207,202
2	Тээврийн хэрэгсэл	93,750,000				93,750,000
3	Тоног төхөөрөмж	157,396,431	33,577,715	1,490,099	1,927,717.5	194,391,962.5
4	Тавилга хэрэгсэл	35,516,940		2,174,003	85,000	37,775,943.7
5	Программ хангамж	880,000				880,000
6	Бусад биет бус хөрөнгө	20,000,000				20,000,000
	Нийт дүн	895,750,573	33,577,715	3,664,102.5	2,012,717.5	935,005,108.2

2023 оны эхэнд 60,981,713 (жаран сая есөн зуун наян нэг долоон зуун арван гурав) төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байснаас 93,158,164 (ерэн гурван сая нэг зуун тавин найман мянга нэг зуун жаран дөрөв) төгрөгийн бараа материалыг худалдан авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн "Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 126 дугаар тогтоолоор 1,332,000 (нэг сая гурван зуун гучин хоёр мянга) төгрөгийн тусгай зориулалтын материал, 219,000 (хоёр зуун арван есөн мянга) төгрөгийн бичиг хэргийн материал, 1,527,633 (нэг сая таван зуун хорин долоо мянга зургаан зуун гучин гурав) төгрөгийн аж ахуйн материал нийт 3,078,633 (гурван сая далан найман мянга зургаан зуун гучин гурав) төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч 83,978,163 (наян гурван сая есөн зуун далан найман мянга нэг зуун жаран гурав) төгрөгийн бараа материалыг зарцуулж оны эцэст 73,240,347.3 (далан гурван сая хоёр зуун мянга гурван зуун дөчин долоо аравны гурав) төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан.

Бараа материал

Хүснэгт-10

№	Үзүүлэлт	2023 он				
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Шилжүүл эн авсан	Зарцуулсан	
1	Тусгай зориулалтын материал	1,871,600		1,332,000	914,200	2,289,400

2	Барилгын засварын материал		2,206,250		2,125,950	80,300
3	Бичиг хэргийн материал	13,182,428.15	11,469,976	219,000	8,389,125	16,482,279.15
4	Аж ахуйн материал	45,927,685.15	9,948,724	1,527,633	3,085,674	54,318,368.15
5	Сэлбэг хэрэгсэл		26,022,600		26,022,600	70,000
6	Хүнсний материал		2,748,050		2,748,050	
7	Түлш, шатах тослох материал		40,692,564		40,692,564	
	Нийт дүн	60,981,713	93,158,164	3,078,633	83,978,163	73,240,347.30

Байгууллагын даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/12 дугаар, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/32 дугаар тушаалуудаар тооллогын комиссыг томилж, эд хөрөнгийн тооллогыг явуулж, тооллогын комисс илтгэх хуудсаар ажлын тайлангаа бичиж, удирдлагадаа танилцуулан ажиллажээ.

2024 оны эхэнд 935,005,108 (есөн зуун гучин таван сая таван мянга нэг зуун найм) төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тухайн онд аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/387 дугаар захирамж болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 20,000,000 (хорин сая) төгрөгийн TOYOTA HARRIER машин, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/201 дүгээр захирамж болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийн ланд-200 авто машин, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/38 дугаар захирамж болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/51 дүгээр тушаалаар 25,400,000 (хорин таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн хэт авиан багаж, 3,850,000 (гурван сая найман зуун тавин мянга) төгрөгийн бетоны агууламж шалгагч багаж, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын зөвшөөрлөөр 14,190,000 (арван дөрвөн сая нэг зуун ерэн мянга) төгрөгийн делл маркийн 3 ширхэг нөүтбүүк, 3,014,000 (гурван сая арван дөрвөн мянга) төгрөгийн таблет 2 ширхэг, 9,976,000 (есөн сая есөн зуун далан зургаа мянга) төгрөгийн суурин компьютер, 2,345,000 (хоёр сая гурван зуун дөчин таван мянга) төгрөгийн 4 ширхэг компьютерийн дэлгэц, 9,856,600 (есөн сая найман зуун тавин зургаа мянга зургаан зуу) төгрөгийн шмитдийн алх, 4,818,010 (дөрвөн сая найман зуун арван найман мянга арав) төгрөгийн делл оптиплекс, 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгийн хурдан скайнер, 1,332,000 (нэг сая гурван зуун гучин хоёр мянга) төгрөгийн MF3010 canon, элсон-3256 маркийн 2 ширхэг принтер, 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгийн санхүүгийн программ нийт 247,421,610 (хоёр зуун дөчин

долоон сая дөрвөн зуун хорин нэгэн мянга зургаан зуун арав) төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 12-ны А/2194 дугаар шийдвэрээр 895,229.13 (найман зуун ерэн таван сая хоёр зуун хорин ес аравны арван гурван мөнгө) төгрөгийн (Dell Opt 7050 i7) Компьютерийг Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас шилжүүлэн авч оны эцэст 1,183,321,947 (нэг тэрбум нэг зуун наян гурван сая гурван зуун хорин нэг мянга есөн зуун дөчин долоо) мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт-11

№	Үзүүлэлт	2023 он				Эцсийн үлдэгдэл
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			
			Төсвийн хөрөнгөөр	Шилжүүлэн авсан	Бусад	
1	Барилга байгууламж	588,207,202				588,207,202
2	Тээврийн хэрэгсэл	93,750,000	170,000,000			263,750,000
3	Тоног төхөөрөмж	194,391,962.5	76,101,610	895,229,13		271,388,801,63
4	Тавилга хэрэгсэл	37,775,943.7				37,775,943.7
5	Программ хангамж	880,000	1,320,000			2,200,000
6	Бусад биет бус хөрөнгө	20,000,000				20,000,000
	Нийт дүн	935,005,108.2	247,421,610	895,229,13		1,183,321,947,33

2024 оны эхэнд 73,240,347 (далан гурван сая хоёр зуун дөчин мянга гурван зуун дөчин долоо) төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байснаас 95,711,225 (ерэн таван сая долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун хорин тав) төгрөгийн бараа материалыг худалдан авч, Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас 1,300,417 (нэг сая гурван зуун мянга дөрвөн зуун арван долоо) төгрөгийн бичиг хэргийн материалыг шилжүүлэн авч 122,078,635 (нэг зуун хорин хоёр сая далан найман мянга зургаан зуун гучин тав) төгрөгийн бараа материалыг зарцуулж оны эцэст 48,173,354 (дөчин найман сая нэг зуун далан гурван мянга гурван зуун тавин дөрөв) төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан.

Бараа материал

Хүснэгт-12

№	Үзүүлэлт	2023 он				Эцсийн үлдэгдэл
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан	
			Төсвийн хөрөнгөөр	Шилжүүлэн авсан	Зарцуулсан	
1	Тусгай зориулалтын материал	2,289,400	360,000			2,649,400
2	Барилгын засварын материал	80,300	2,562,220		2,499,220	143,300
3	Бичиг хэргийн материал	16,482,279.15	10,983,800	1,300,417	21,310,835,40	7,455,661
4	Аж ахуйн материал	54,318,368.15	6,835,800		26,540,412,75	34,613,755,4
5	Сэлбэг хэрэгсэл	70,000	24,814,500		24,642,500	242,000
6	Түлш шатах тослох материал		45,128,190		45,128,190	
7	Хүнсний материал		1,957,476,8		1,957,476,8	

8	Бусад хангамжийн материал		3,069,237.88			3,069,237.88
	Нийт дүн	73,240,347.30	95,711,224.68	1,300,417.25	122,078,634.9	48,173,354.28

Байгууллагын даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/62 дугаар, 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/75 дугаар тушаалуудаар хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогын комиссыг томилж, эд хөрөнгийн тооллогыг явуулж, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд тооцоо бодсон актыг үйлдэн, тооллогын комисс ажлын тайлангаа бичиж, удирдлагадаа танилцуулан ажиллажээ.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны А/19 дүгээр тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл" 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, тухайн онд тус зөвлөл 3 удаа хуралдаж, 2023 онд хэрэгжүүлэх 7 ажил, 2024 онд хэрэгжүүлэх 7 ажлыг хийхээр төлөвлөсний дагуу хийж, ажлын тайлан гарган ажиллажээ.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт;

2023 нягтлан бодох бүртгэлийн "Acolous", 2024 онд "Fiscus" онлайн программ, төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээр бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийг гарган, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст, ГЗБГЗЗЕГазарт төсвийн гүйцэтгэлийн тайлан, сар бүрийн мэдээг өгч, НДШ-ийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг сар, улирал тутамд цахимаар илгээж, цаасаар баталгаажуулсан. Төсөв хөрөнгийг зарцуулахдаа нотлох баримтууд болох тушаал, шийдвэр, харилцагч иргэн, байгууллагын нэхэмжлэх, зарлагын баримт, төлбөрийн и-баримт зэргийг хавсарган, хагас бүтэн жилээр тооцоо нийлсэн актыг үйлдэн өр авлагаа баталгаажуулан ажиллаж байгаа боловч 2023 онд жолооч С.Мөнхтогтохд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохдоо нэгдэл дундын үйлдвэрт ажилласан 1 жил 4 сарыг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцож 1-5 дугаар сард 1 хувь, 6-8 дугаар сард 2 хувь, 9-12 дугаар сард 1 хувиар илүү олгож 103,068 (нэг зуун гурван мянга жаран найм) төгрөг, 2024 онд 1-4 дүгээрсард 1 хувь, 5-9 дүгээр сард 2 хувь, 10-12 дугаар сард 1 хувиар илүү олгож 164,890 (нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун ер) төгрөг нийт 267,958 (хоёр зуун жаран долоо мянга есөн зуун тавин найм) төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү олгосон, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны Б/44 дүгээр тушаалаар Д.Төрбатыг 11 дүгээр сарын 01-ний өдрөөс гэрээ байгуулж жолоочоор ажиллуулсан боловч тушаал шийдвэргүйгээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 11, 12 дугаар сард тус бүр 22 хувиар бодож нийт 347,656 (гурван зуун дөчин долоо мянга зургаан зуун тавин зургаа) төгрөг илүү олгосон, 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр газрын дарга Т.Ариунболд Улаанбаатар хотод 5 хоног ажиллуулахаар томилж, томилолтыг олгохдоо томилолтын хуудсанд буцсан өдрийг зассан засвартай баримт үндэслэн 994,000 (есөн зуун ерэн дөрвөн мянга) төгрөг олгосон, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Барилгын хэлтсийн барилгын хяналтын ахлах мэргэжилтэн Ц.Нямдалай Хайрхандулаан суманд, 01 дүгээр сарын 17-ны өдөр Нарийнтээп

суманд ажилласан томилолт бодож олгохдоо олгохыг зөвшөөрч баталгаажуулалт хийгдээгүй, байхад тус бүр 64,000 (жаран дөрвөн мянга) төгрөг, Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга А.Энхцэцэгт Хөвсгөл аймагт 2023 оны 06 дугаар сарын 01-03-ны өдрийг хүртэл ажилласан томилолт бодож олгохдоо томилолтоор ажилласан өдрийн сунгалт хийгээгүй байхад 1 өдөр илүү ажиллуулж 118,000 (нэг зуун арван найман мянга) төгрөг бодож олгосон, 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Жолооч С.Мөнхтогтох Хужирт, Бат-Өлзий сумдад ажилласан 1 хоногийн томилолт, 06 дугаар сарын 12-ны өдөр лаборант Б.Мөнхцэцэг Хужирт, Хархорин сумдад ажилласан 1 хоногийн томилолт, 08 дугаар сарын 06-ны өдөр газрын даамал А.Балжинням Сант, Баян-Өндөр сумдад ажилласан 1 хоногийн томилолт, 12 дугаар сарын 24-ний өдөр Газрын удирдлагын хэлтсийн дарга Ц.Хашхүү Хархорин суманд ажилласан 1 хоногийн томилолт, Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Нямдалайд Баян-Өндөр суманд ажилласан 1 хоногийн томилолт, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч С.Нямдоржид Хархорин суманд ажилласан 1 хоногийн томилолт, 05 дугаар сарын 28-ны өдөр Барилга хот байгуулалтын хэлтсийн шинжээч Б.Мөнхцэцэгт Хужирт суманд ажилласан 1 хоногийн томилолт, архивын ажилтан А.Отгонцэнгэлд Баруунбаян-Улаан, Хайрхандулаан сумдад ажилласан 1 хоногийн томилолтыг бодож олгохдоо томилолтын хуудсанд ирсэн буцсан он, сар, өдөр бичигдээгүй байхад нийт 720,000 (долоон зуун хорин мянга) төгрөг, 09 дүгээр сарын 27-ны өдөр суурь, судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Аравзайлхам Улаанбаатар хотод ажилласан томилолт бодож олгохдоо томилолтын хуудсанд ирсэн буцсан он, сар, өдөр бичигдээгүй байхад 600,000 (зургаан зуун мянга) төгрөг, Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн С.Мөнх-Эрдэнэд Улаанбаатар хотод ажилласан томилолт бодож олгохдоо томилолтын хуудсанд ирсэн буцсан он, сар, өдөр бичигдээгүй байхад 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг нийт 2,960,000 (хоёр сая есөн зуун жаран мянга) төгрөгийн томилолтыг олгосон, томилолт бодож олгохдоо ажлын тайлан гүйцэтгэл дутуу бичүүлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

4.8. Хандив, тусламжийн хөрөнгө түүний зарцуулалт;

Тухайн онуудад төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4.9. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт;

2023 онд дулаанаар хангах Арвай палас ХХК-тай 1885 м³ талбайг 1467,5 (нэг мянга дөрвөн зуун жаран долоон төгрөг таван мөнгө) төгрөгөөр нийт 22,129,920 (хорин хоёр сая нэг зуун хорин есөн мянга есөн зуун хорь) төгрөгөөр гэрээг байгуулж тухайн онд түлш халаалтын зардлаас 22,129,920 (хорин хоёр сая нэг зуун хорин есөн мянга есөн зуун хорь) төгрөгийг шилжүүлсэн, шатахуун худалдан авах гэрээг Ник ХХК-тай, бараа материал худалдан авах гэрээг Энх-Энкол ХХК-тай, Түмэн наст худалдааны төвтэй, авто тээврийн даатгалын гэрээг Практикал Даатгал ХХК-тай, ажилчдын цалин түүнтэй адилтгах орлогыг олгох гэрээг Хаан банк ХХК-тай, Төрийн банк ХХК-тай, бичиг хэрэг худалдан авах гэрээг Best бичиг хэргийн бөөний дэлгүүртэй, шуудан холбооны гэрээг Монгол шуудан ХК-тай 2

жилийн хугацаатай гэрээ байгуулсан, хог хаягдлыг зайлуулах гэрээг Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай, архивын баримт бичгийг хадгаламжийн нэгжид шилжүүлэхэд хамтран ажиллах гэрээг С.Пүрэвсүрэнгэй ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажилласан байна.

2024 онд дулаанаар хангах Арвай палас ХХК-тай 2085м³ талбайг 1,640,7 (нэг мянга зургаан зуун дөчин төгрөг долоо мөнгө) төгрөгөөр буюу жилийн 27,366,873 (хорин долоон сая гурван зуун жаран зургаан мянга найман зуун далан гурав) төгрөгөөр гэрээг байгуулж тухайн онд түлш халаалтын зардлаас 27,366,873 (хорин долоон сая гурван зуун жаран зургаа мянга найман зуун далан гурав) төгрөгийг шилжүүлсэн, авто тээврийн даатгалын гэрээг Практикал Даатгал ХХК-тай, ажилчдын цалин түүнтэй адилтгах орлогыг олгох гэрээг ХААН банк ХХК-тай, ус суваг ашиглалтын гэрээг Онги Ус Суваг ОНӨААТҮГ-тай, шуудан холбооны гэрээг Монгол шуудан ХК-тай, хог хаягдлыг зайлуулах гэрээг Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай, шмитийн алх худалдан авах шууд гэрээг Эн Ди Ти Эс ХХК-тай, компьютер тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хор цэнэглэлт, дагалдах хэрэгсэл худалдан авах гэрээг Өв цахим сүлжээ ХХК-тай, автомашин худалдан авах гэрээг Дэвжих аг ХХК-тай, компьютер, хэвлэгч худалдан авах гэрээг СТ биг Капитал Пропертис ХХК-тай, авто машины сэлбэг худалдан авах гэрээг Өрнөх уран ХХК-тай гэрээг тус тус байгуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажилласан байна.

Тав. Шалгагдсан байгууллагад өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023, 2024 онуудын санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой удирдлагаас гаргасан шийдвэрүүд, ажилтнуудын цагийн бүртгэл, албан тушаалын цалин тогтоолт, цалингаас татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцоолж суутгасан эсэх, нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага зөв тусгагдсан эсэх, орлого төвлөрүүлэлт, хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны баримт бүрдүүлэлт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн байдал, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, цаг хугацаандаа бэлтгэгдсэн байдал зэрэгт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт 1: Тухайн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж, санхүүгийн тайлан баланс, ажил гүйлгээний мэдээ, тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвшсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлт сайн байгаа боловч төрийн алба хаасан хугацаанд хувийн хэвшилд ажилласан жилийг оруулан тооцсон, тушаал шийдвэргүйгээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон, томилолт олгохдоо олгохыг зөвшөөрч баталгаажуулалт хийгдээгүй, томилолтын хуудсанд ирсэн буцсан он, сар, өдөр бичигдээгүй, ажлын тайлан гүйцэтгэл дутуу бичүүлж томилолт олгосон зэрэг зөрчлүүд нь албан тушаалтнууд ажилдаа хайнга хандсантай холбоотой гэж үзлээ.

Дүгнэлт 2: Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд 2022 оноос өмнө шийдвэр нь гарсан 2478 нэгж талбарын мэдээллийг оруулаагүй, газрын даамлууд оруулсан

мэдээллээ хянадаггүй, 7 сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа улсын чанартай хатуу хучилттай авто замын газрын төлбөрийг ногдуулаагүй, газраа ашиглаж байгаа боловч газрын төлбөрийн ногдолт хийгдээгүй, төлөөгүй, ГНСТ-8 тайланд өмнөх онуудын газрын төлбөрийн авлага, өглөг огт тусгагдаагүй, зөвхөн тайлант оноор тусгагддаг, сумдын болон аймгийн нэгдсэн санхүүгийн тайланд өглөг, авлага нь тусгагддаггүй, газрын төлбөрийн өглөг, авлагын тооцоог шат шатандаа хийдэггүй, газар зохион байгуулалтын тайлангуудыг гараар гаргадаг зэрэг нь газрын кадастрын мэдээллийн системийн хөгжүүлэлт муу, алдаатай ажилладаг, системд оруулах ёстой газар олголтын мэдээлэл бүрэн орж дуусаагүй байгаа, татварын системээс төлбөрийн ногдуулалт, үүссэн өглөг, авлагын мэдээлэл нэгтгэгдэж харагддаггүй, газар олгохоор аймаг, сумын Засаг даргын захирамж гарснаас хойш газрын кадастрын мэдээллийн системд захирамж болон бусад мэдээлэл, хавсралт файлуудыг хэдийд ямар хугацаанд оруулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ авах ёстой талаар зохицуулсан эрх зүйн акт байхгүй, системийн хэмжээнд газрын төлбөрийн авлага, өглөгийн тооцоо нийлдэггүй, бүх шатанд мэдээллийн чанарт тавих хяналт сул, газрын даамлууд ажилдаа хариуцлагагүй хайнга ханддаг, сумдад газрын даамлаар ажиллах хүн олддоггүй зэргээс үүдэлтэй гэж дүгнэлээ.

Энэ удаагийн шалгалтаар анхан шатны баримттай холбоотой 2,960,000 (хоёр сая есөн зуун жаран мянга) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл илүү бодож олгосон 615,614 (зургаан зуун арван таван мянга зургаан зуун арван дөрөв) төгрөг, үйл ажиллагаатай холбоотой нийт 3,575,614 (гурван сая таван зуун далан таван мянга зургаан зуун арван дөрөв) төгрөгийн, газрын төлбөрийг дутуу ногдуулсан 53,476,636 (тавин гурван сая дөрвөн зуун далан зургаан мянга зургаан зуун гучин зургаа) төгрөг, ГНСТ-8 болон санхүүгийн тайланд тусгаагүй авлага 688,670,317.88 (зургаан зуун наян найман сая зургаан зуун далан мянга гурван зуун арван долоон төгрөг, наян найман мөнгө) төгрөг газрын төлбөртэй холбоотой нийт 742,146,953.88 (долоон зуун дөчин хоёр сая нэг зуун дөчин зургаан мянга есөн зуун тавин гурван төгрөг, наян найман мөнгө) төгрөгийн зөрчил илэрч, 615,614 (зургаан зуун арван таван мянга зургаан зуун арван дөрөв) төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн акт, илэрсэн газрын төлбөртэй холбоотой илэрсэн зөрчлийг арилгуулахаар 6 заалт, үйл ажиллагаатай холбоотой 2 заалт бүхий зөвлөмжийг өгч ажиллалаа.

Зургаа. Цаашид анхаарах асуудлууд:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт

1. Газрын кадастрын мэдээллийн системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох, системээс үүссэн алдаанууд гарахгүй байхаар тохируулга хийх. Мэдээллийн баазыг тайлант оноор нь бааз үүсгэж, холбогдох тайлангуудыг системээс автоматаар үнэн зөв гаргадаг болгох;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст

1. Сум, аймгийн нэгдсэн санхүүгийн тайланд газрын төлбөрийн өр, авлагыг тусгаж, авлага, өглөгийг насжилтаар нь гаргаж, барагдуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах;

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт

1. Сумдын газрын даамлууд Засаг даргын захирамж гарснаас хойш газрын кадастрын мэдээллийн системд захирамж болон бусад мэдээлэл, хавсралт файлуудыг "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай" хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж хэвших;

2. Сумдын татварын улсын байцаагч, газрын даамлууд жилийн эцэст газрын төлбөрийн өмнөх онуудын дутуу төлөлт, тухайн жилийн ногдуулалт, төлөлтийн дүнг газар эзэмшигч бүрээр гарган тооцоо нийлж, хэвших;

3. Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн тайланд (ГНСТ-8) өмнөх онуудын авлага, өглөгийг тусгадаг байх;

4. Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгож, мэдээллүүдийн зөрүүтэй байдлыг арилгах арга хэмжээ авч ажиллах;

5. Сумдын газрын даамлуудын оруулсан мэдээллийг тогтмол хянаж, мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж ажиллах;

6. Албан томилолтоор ажилласан албан хаагч нар томилолтоор ажилласан ажлын гүйцэтгэл, ирсэн буцсан өдрийн бичилт хийгдсэн эсэхийг хянан, ажлыг нь дүгнэж зөвшөөрсөн гарын үсэг, зурж баталгаажсаны дараа зардлыг олгож хэвших;

7. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг цалин бодох тухай бүр нягтлан шалгаж, хүний нөөцийн болон цалингийн нэгдсэн системийн мэдээллийн уялдааг хангаж ажиллах;

Дээрх өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажиллан, авсан арга хэмжээг ажлын тайлангийн хамт албан бичгээр 2025 оны 07 дугаар сарын 01-ний дотор хариу ирүүлэхийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнуудад үүрэг болгов.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  С.ДУЛАМЖАРГАЛ

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Ч.БУЯНБАТ
 Д.ЧУЛУУНБАДРАХ
 Э.ЭНХТУЯА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА  М.ЭРДЭНЭЧУЛУУН

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  Т.АРИУНБОЛД

НЯГТЛАН БОДОВЧ  Д.ЗОЛЗАЯА

